Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал.	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0,5	5
Хэсгийн оноо				**4**	**3**	**30**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх.		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал.		1	0,5	0
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2,5**	**20**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн, хөдөлгөөний бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал,		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8,5**	**85**

$$\text{Эзлэх хувь}=\frac{\text{ҮХХ}+\text{ЁЗМ}+\text{ЁЗДХ}}{10}*100\%=\frac{3+2,5+3}{10}*100\%=85\%$$

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ. Товч танилцуулга
Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024.10.29-ний өдрийн А/374 дүгээр тушаалаар ОБЕГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд Ёс зүйн 36 дэд хороо, 252 хүний бүрэлдэхүүнтэйгээр хууль тогтоомж, хөтөлбөр, албан даалгавар, албан бичгийн хэрэгжилтийг ханган ажилласан. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний 2025 оны сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 69 төрлийн сургалт, дадлагад төрийн алба, төрийн албан хаагчийн ёс зүйн хичээлийг багтааж, ёс зүй, хандлага, харилцааг төлөвшүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд гарсан сахилга, ёс зүйн зөрчлийн тоог өнгөрсөн оны зөрчлийн тоотой харьцуулбал 3,8%-аар буурсан үзүүлэлттэй байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт.
Төрийн албан хаагчийн ёс зүй, авлигын эсрэг үйл ажиллагаа зэрэг нийт 6 төрлийн мэдээллийг (рийл-2, постер-3, мэдээ-1) бэлтгэн "Онцгой байдлын ерөнхий газар" пейж хуудсанд байршуулахад давхардсан тоогоор 238.717 хүнд хүрсэн. Онцгой байдлын байгууллагаас сар бүр эрхлэн гаргадаг "Онцгой мэдээ" сонины 2025 оны 07 сарын дугаарт "Төрийн албан хаагчийн онцлог, ёсзүйн зарчим, эрхэмлэх зүйл" сэдвийн хүрээнд хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийтлэл, 08 сарын дугаарт "Төрийн албан хаагчдын ёс зүйн төлөвшил тэдний хөгжлийн түвшинг илэрхийлэх хэмжүүр болдог" нийтлэл, 09 сарын дугаарт "Хариуцлагатай, чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр" нийтлэлийг тус тус бэлтгэн, хэвлүүлж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын давхардсан тоогоор 9000 гаруй алба хаагчдад хүргэсэн байна.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Томилох эрх бүхий албан тушаалтан нь ёс зүйн дүрэм, хууль тогтоомжийг өөрөө чанд мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжин, байгууллагад ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд манлайлан ажилласан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар алба хаагчдыг соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох, гүйцэтгэлийн үнэлгээнд болон сахилгын зөрчилд үндэслэн тухай бүр үр дүнд тохирсон хариуцлага тооцох ажлыг зохион байгуулан, хяналт тавьж ажилласан.
Монгол Улсын 21 аймгийн Онцгой байдлын газар, нэгжүүдэд ажиллахдаа ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, тодорхой үүрэг чиглэлийг өгсөн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/", Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" Ёс зүйн дэд хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 10 дугаар тогтоол, 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн "Журам батлах тухай" 13 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах хүрээнд Онцгой байдлын байгууллагад 2025 онд дараах ажил, арга хэмжээнд зохион байгуулласан. Үүнд:

- Онцгой байдлын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн №03 Ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай албан даалгаврыг Төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагад хүргүүлсэн.
- Онцгой байдлын ерөнхий газрын 2025.04.10-ны 03/985, 2025.05.13-ны 03/1375, 2025.08.25-ны 03/2351 албан бичгүүдээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажилласан.
- Сар, улирал, хагас жил, жилээр төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, биелэлт болон төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэл мэдээллийг нэгтгэн гаргасан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Тайлант хугацаанд зохион байгуулсан ажил, арга хэмжээний хүрээнд 2025 оны сахилга, ёс зүйн зөрчлийн тоог 2024 оны зөрчлийн тоотой харьцуулбал 3,8%-аар буурсан үзүүлэлттэй байна.	Сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг Ёс зүйн дэд хороогоор хянан шийдвэрлүүлж, дарга, захирагчийн шийдвэр гаргах ажиллагаанд санал гарган ажиллаж байгаа нь "Ёс зүйн шийтгэл", "Сахилгын шийтгэл" гэсэн хууль тогтоомжоор тусгайлан зохицуулсан харилцааг нэгтгэн ажиллаж байгаа дутагдалтай талтай байна.

Санал:

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хурал, зөвлөгөөн, сургалт, соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

Шалгах хэсэг:

- [x] “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- [x] Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- [x] Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Томилох эрх бүхий албан тушаалтан:

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга:

ЗАХИРГАА, ЭРХ ЗҮЙ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Б.ҮНЭНБААТАР

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДЭД ХУРАНДАА Э.АМГАЛАН

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

БАТЛАВ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ХУРАНДАА Б.ҮНЭНБААТАР

2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүйн төлөвшил, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, алба хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг зохион байгуулах.

	хэрэгжүүлэх зорилт, хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Төсөв	Хариуцах нэгж
НЭГ. ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР							
1.	Алба хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	Сургалт	Сургалтын хөтөлбөр, удирдамж	4	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
2.	Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр батлуулж, хуралдаан зохион байгуулах	Төлөвлөгөө	Төлөвлөгөөний төсөл	4	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
3.	Ёс зүйн асуудлыг зохицуулахаар гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангаж ажиллах.	Хэрэгжилтийн тайлан	Тогтоол, шийдвэр	Гүйцэтгэлийн хувь	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
4.	Онцгой байдлын байгууллагын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих.	Хэрэгжилтийн тайлан	Батлагдсан дүрэм	Гүйцэтгэлийн хувь	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
5.	“Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах	Хэлэлцүүлэг	Дүрэм	100%	II-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо

ХОЁР. САХИЛГА, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР							
6.	Салбар, нэгжийн ёс зүйн дэд хороог чадавхжуулах, мэрэгжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан, дэмжлэг үзүүлсэн ажлын тоо	-	Гүйцэтгэлийн тоо	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
7.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөлөл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоо	-	Гүйцэтгэлийн тоо	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ЧИГЛЭЛЭЭР							
8.	Ёс зүйн зөрчил гаргах шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийж салбар, нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх.	Зөвлөмж хүргүүлсэн тоо	-	Гүйцэтгэлийн хувь	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
9.	Иргэн, албан хаагч, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Тайлан мэдээний тоо	-	100%		-	Ёс зүйн дэд хороо
10.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны баримт бичгийг архивын нэгж үүсгэж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Архивын баримтын тоо	-	100%	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
11.	Албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	100%	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо
12.	Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг бүртгэх.	Тайлан	-	100%	I-IV улирал	-	Ёс зүйн дэд хороо

--oOo--